



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 одор

Дугаар A/332

Чойбалсан

Г Түгээмэл тархацтай ашигт малтмалын 7
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 11.2.6 19 дүгээр зүйлийн 19.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.2.2, 16.2.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорнод аймгийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 221/2024/0435 дугаартай магадлалыг үндэслэн Хэрлэн сум, 5 дугаар баг, Зүүн Өлзийт гэх газарт 26,2 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "ТОУУ" ХХК-д олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Дамдинбазар)-т үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд явуулж буй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч (С.Мөнхжаргал), Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс (Г.Эрдэнэбаатар), Байгаль орчны газар (А.Гантулга), ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг аймгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Гэрэлцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ



My computer D/ Zakhiramj

2125010870